

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2024 оны 6 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

Үнэлгээний зорилго, арга зүй

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаанд 2024 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах ажлын талаар зөвлөмж боловсруулах замаар Хууль зүй, дотоод хэргийн яам болон Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, гарсан дүгнэлт, зөвлөмжийг дараагийн бодлого, шийдвэр, төлөвлөгөөнд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг баримталсан.

Тус хүрээлэнгийн 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг дараах 4 бүлэгт хуваан үнэлгээ өгсөн. Үүнд:

- Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ
- Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ
- Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ зэрэг болно.

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ

1.1. “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт

Монгол улсын Улсын их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод 1 зорилтын хүрээнд тус хүрээлэнгээс 2024 онд 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээс тусгагдсанаас эхний хагас жилд 2 арга хэмжээ, сүүлийн хагас жилд 2 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хэрэгжүүлсэн 2 арга хэмжээний биелэлтийг үнэлэхэд “үр дүнтэй” 100 хувьтай байна.

№	Төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/						Биелэлт /хувиар/
		100	90	70	50	30	0	
1.	2	2	-	-	-	-	-	100

/Биелэлтийг Хавсралт №1-ээс үзнэ үү/

1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт

Монгол Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.4.4, 4.4.7, 4.4.9 зорилтын хүрээнд 2024 оны эхний хагас жилд 5 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна.

Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/						Биелэлт /хувиар/
		100	90	70	50	30	0	
1.	4.4.7	2	-	-	-	-	-	100
2.	4.4.9	3	-	-	-	-	-	100
Нийт		5	-	-	-	-	-	100

2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ

№	Тогтоолын дугаар	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний гүйцэтгэл /хувиар/					Биелэлт
			100	70	30	0	Хугацаа болоогүй	хувь
Ерөнхийлөгчийн зарлиг								
1	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019_60	1	100	-	-	-	-	100
2	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	2	100	-	-	-	-	100
3	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	2	100	-	-	-	-	100
Хуулийн хэрэгжилт								
4	Статистикийн тухай хууль	1	100	-	-	-	-	100
5	Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2015-05-29	2	100	-	-	-	-	100
Засгийн газрын тогтоол								
6	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	1	100	-	-	-	-	100
УИХ-ын тогтоол								
7	УИХ-ын 2023.07.07-ны өдрийн 77 дугаар тогтоол	1	100	-	-	-	-	100

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 7 арга хэмжээний хүрээнд 15 ажил зохион байгуулсан үнэлгээг хийхэд биелэлт 100 хувь байна. /Биелэлтийг Хавсралт №3-аас үзнэ үү./

Монгол улсын “Статистикийн тухай” хуулийн хүрээнд статистик мэдээг 5 удаа, инфографик мэдээг 3 удаа албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

3. Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ

3.1. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ

Эхний хагас жилд 46 арга хэмжээг хэрэгжүүлсэн байдлыг үнэлэхэд “үр дүнтэй” буюу 100%-тай 45, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70%-тай 1 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт 99,3 хувьтай байна. 2024 оны төлөвлөгөөнд нийт 55 арга хэмжээ тусгагдсанаас сүүлийн хагас жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 9 арга хэмжээ байна.

Хариуцсан чиг үүргээр нь авч үзвэл:

	Үндсэн чиг үүрэг	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ /хувиар/						Хэрэгжилт /хувиар/
			100	90	70	50	30	0	
1	Үндсэн чиг үүрэг №1.	10	10	-	-	-	-	-	100

	/ХЗҮХ-гийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 1/								
2	Үндсэн чиг үүрэг №2. хөгжүүлэх /ХЗҮХ-гийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 2/	1	-	-	1	-	-	-	70
3	Үндсэн чиг үүрэг №3. хөгжүүлэх /ХЗҮХ-гийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 3/	20	20	-	-	-	-	-	100
4	Үндсэн чиг үүрэг №4. хөгжүүлэх /ХЗҮХ-гийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 4/	14	14	-	-	-	-	-	100
5	Үндсэн чиг үүрэг №5. хөгжүүлэх /ХЗҮХ-гийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 5/	1	1	-	-	-	-	-	100
Нийт		46	45	-	1	-	-	-	99,3

2024 оны III, IV дүгээр улиралд доорх ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлууд хийгдэж байна.

1. “Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” судалгаа. /судалгаанд холбогдох эх сурвалжийг түүвэрлэн судалж байна./

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14¹ дүгээр бүлэг буюу “Арбитрын ажиллагаанд шүүх оролцох эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх” судалгаа. /удирдамж, төлөвлөгөөг боловсруулж, эх сурвалжийн жагсаалт гаргасан/

3. “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” судалгааны хүрээг “Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар нэхэмжлэл гаргах, хэд хэдэн оролцогч хамтран нэхэмжлэл гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлэх нь” болгож өөрчилсөн. /судалгаанд холбогдох эх сурвалжийг түүвэрлэн судалж, удирдамж төлөвлөгөө боловсруулсан/

4. “Зөрчлийн тухай хуулийн хэрэглээнд тулгамдаж байгаа асуудал” сэдэвт судалгаа хийх

5. “Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл, илтгэл шалгаруулах, грант олгох төсөл шалгаруулах уралдаан-2024 зохион байгуулах тухай” ДХИС, ХЗҮХ-ийн захирлын хамтарсан тушаал батлагдсан. /тус уралдааныг зохион байгуулах бэлтгэл шатны ажлууд үргэлжилж байна/

6. Эрдмийн зөвлөлийн хурал

7. Хууль сахиулах байгууллагын албан хаагчдад хүний эрхийн хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт

8. Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцын талаар өмгөөлөгч, хуульчдад сургалт

9. Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад эрх зүйн албан бус сургалтыг зохион байгуулах

3.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн үнэлгээ

2024 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн А/15 тоот тушаалаар “Хууль зүйн үндсэний хүрээлэнгийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ыг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.2.1.Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхижүүлэх

Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр 2024 оны дотоод сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Дотоод сургалтын төлөвлөгөөний эхний хагас жилийн хугацаанд 8 удаагийн арга хэмжээний хүрээнд 24 удаагийн сургалтад алба хаагчдыг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж, 279 албан хаагч (давхардсан тоогоор) хамрагдсан байна. Мэргэшүүлэх 14 сургалтад (давхардсан тоогоор) 79 алба хаагч хамрагдсан байна. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал эхний хагас жилийн байдлаар 5,320,981 төгрөг байна.

Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хүрээнд эхний хагас жилийн байдлаар ажлаас гарсан 9, шинээр ажилд орсон 12, гадаадын их дээд сургуульд суралцаж байгаа 2, хүүхэд асрах чөлөөтэй 5 алба хаагч байна. Холбогдох мэдээллийг хүний нөөцийн нэгдсэн системийн програмд тус тус оруулсан.

3.2.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах

1. Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь нь тайлант хугацаанд 13.6% хувийг зарцуулсан байна.

2. 2024.04.24-ны өдрийн захирлын тушаалаар албан хаагчдад олгох хоолны мөнгөний хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан 20.000 төгрөгийн хоол, 8000 унааны нэмэгдлийг хоногт олгож ажилласан.

3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2024 оны 6 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн иргэдийн хэрэглээний боловсролын төвөөс "Эрүүл амьдралын зөв дадал зуршил" сургалтын хүрээнд сэтгэл зүй, нойр, хоол зүй, дархлаа сэдвээр сургалт орж нийт 25 албан хаагч хамрагдсан.

№	Үндсэн чиг үүрэг	Нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/					Биелэлт /хувиар/
			100	70	30	00	ХБ	
1	Төрийн албан хаагчын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн үнэлгээ	7	7					100
	Дүн	7	7					100

/Биелэлтийг Хавсралт №4-өөс үзнэ үү/

4. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

4.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 9 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг гаргаж ил тод байдлын үнэлгээг гүйцэтгэлээ.

Байгууллагын www.nli.gov.mn цахим хуудсанд байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харицах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг, ажиллах цагийн хуваарь зэргийг цахим хуудас тухай бүр шинэчлэн байршуулж ажилласан байна.

4.2. Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд байгууллагын <https://nli.gov.mn> цахим хуудсанд эхний хагас жилийн байдлаар 11 сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас www.nli.gov.mn байршуулж, олон нийтийн сүлжээнд иргэдэд нээлттэй танилцуулсан.

Албан хаагчийн ёс зүйн дүрмийг www.nli.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүр шинэчлэн ажилласан.

№	Нийт арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/					Биелэлт /хувиар/
			100	70	30	0	Хугацаа болоогүй	
1	Үйл ажиллагааны ил тод байдал	4	4	-	-	-	-	100
2	Хүний нөөцийн ил тод байдал	5	5	-	-	-	-	100
	Нийт	9	9	-	-	-	-	100

4.3. Шилэн дансны мэдээлэл

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн вэб сайт www.shilendans.gov.mn -д төсөв, гүйцэтгэлийн чиглэлээр 26, хөрөнгө оруулалт, худалдан авалт, тендэрийн чиглэлээр 17, бусад чиглэлээр 30, нийт 29 чиглэлийн хүрээнд 183 мэдээ байршуулахаас 73 төрлийн мэдээг цаг хугацаанд нь байршуулсан, хугацаа хоцроосон мэдээ байхгүй. 110 мэдээллийн байршуулах хугацаа болоогүй байгаа ба хэрэгжилт 100 хувьтай байна.

№	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээллийн тоо	Байршуулсан мэдээллийн тоо	Тайлант хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан				Биелэлт /хувиар/
				100	70	30	0	Хугацаа болоогүй	
1	Төсөв, гүйцэтгэл	71	26	26	-	-	-	45	100
2	Хөрөнгө оруулалт, тендэр, худалдан авалт	39	17	17	-	-	-	22	100
3	Бусад	73	30	30	-	-	-	43	100
	Дүн	183	73	73	-	-	-	110	100

Дүгнэлт

Алсыг хараа 2050 бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөөний хэрэгжилт, Ил тод байдал, шилэн дансны хөтлөлтийн биелэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж ажилласан. Засгийн газрын 2020 оны 206 дугаар дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаанд 2024 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүнг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт		Хувь
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. “Алсын хараа 2050”	100
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ	100
	1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	99,3

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100
	2. Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ	100
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	100
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	-
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-
Нийт үнэлгээ:		99,9

Шударга байдлын үнэлгээг АТГ-аас , хэрэглэгчийн үнэлгээг ЗГХЭГ нэгдсэн байдлаар үнэлгээг хийдэг.

Санал, зөвлөмж

Үнэлгээг хийхдээ ХЗДХЯ-ны 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан болно.

1. Төрийн албан хаагчын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2024.03.14-ны өдрийн А/15 тоот тушаалаар баталж төлөвлөгөө болосруулан хэрэгжүүлж байна.

2. Төрийн албан хаагчын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн тайланг холбогдох журам, хавсралтын дагуу гаргасан.

3. Бодлогын баримт, бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа “нийтлэг журам”-ын 6.8-д заасны дагуу тайлагнасан.

4. Байгууллагын үйл ажиллагааг тайланг 2024 оны 6 дугаар сарын 07-ны өдөр Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж мөн өдрийн 01/244 тоот албан бичгээр хүргүүлсэн.

5. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3,Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2.Цаашид Хууль зүй дотоод хэргийн яамнаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу хяналт тавьж ажиллах.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН